

ЭНЭТХЭГИЙН ТУСЛАЛЦАА - МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ СУРГАЛТАД

*Ж.Юра /Ражив Гандийн нэрэмжит
Үйлдвэрлэл-Урлалын сургууль/*

Өнө эртний түүхтэй Монгол, Энэтхэг хоёр орны соёлын хэлхээ холбоо өдгөө цаг дор үлэмж амжилттай хөгжиж байгааг олон баримтаар дурдаж болох юм. Тухайлбал БНЭУ-ын техник, мэргэжилтний буцалтгүй туслалцаа хэрэгжиж байгаа А.Важпайн нэрэмжит Холбоо мэдээллийн технологийн сургууль, Монгол, Энэтхэгийн хамтарсан Ерөнхий боловсролын сургууль, Ражив Гандийн нэрэмжит Үйлдвэрлэл-Урлалын сургууль зэрэг хоёр орны найрамдалт харилцааны билэг тэмдэг болсон боловсролын байгууллагууд үүний нэг тод жишээ юм. Тэр тусмаа манай орны боловсролын нэг чухал салбар болсон мэргэжилтэй ажилчин бэлтгэх сургуулийн үйл ажиллагааны эгзэгтэй үе буюу 1990-ээд оны дунд үед хөрөнгө оруулалт хийж, дэмжлэг үзүүлэх санаачилга гаргасан анхны орон бол Энэтхэг улс байсан юм. Энэ туслалцаа нь монголын мэргэжлийн боловсрол, сургалтад хэрэгжих олон дэмжлэг тусламжийн эхлэл болсон төдийгүй, гадаад орнуудад энэ чиглэлийн туслалцаа монголын ирээдүйд нэн чухал гэдгийг харуулснаараа ач холбогдолтой гэж бид үздэг юм.

Энэтхэг улсын төр, нийгмийн нэрт зүтгэлтэн Ражив Гандийн нэрээр монголчуудын дотор аль хэдийнээ танил болсон Үйлдвэрлэл-Урлалын сургуульд Энэтхэг улсын туслалцаа хэрхэн хэрэгжиж, ямар үр дүнд хүрсэнийг товчхон өгүүлье.

Одоогоос 10 гаруй жилийн өмнө Монгол улсын боловсрол, тэр дундаа мэргэжлийн боловсрол сургалтын салбар үндсэндээ зогсонги байдалд байсан гэж болохоор үе л дээ. Энэ салбарт суралцагсдын тоо бараг 4 гаруй дахин цөөрч, олон сургууль татан буугдаж, төгсөгчдийг ажлаар хангах асуудлыг зохицуулах боломжгүй болсон байлаа. Ийм цаг үед Монгол улсын засгийн газраас мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүдийг гадаадын техникийн туслалцаатай шинэчлэх тухай хэд хэдэн улстай яриа хэлэлцээ болсон байдаг юм. Эдгээр яриа, хэлэлцээрээс хамгийн түрүүн ажил хэрэг болж, өнөө хүртэл үргэлжилж байгаа техникийн томоохон туслалцааны нэг нь БНЭУ-аас Улаанбаатар хот дахь Ражив Гандийн нэрэмжит Үйлдвэрлэл-Урлалын сургуулийг бэхжүүлэх төсөл юм.

1996 оны өвөл тус сургуулийн 5 багш анх удаа Энэтхэг орныг зорьж, мэргэжил дээшлүүлэх болсон нь тухайн үедээ ховорхон завшаан байсан бөгөөд Энэтхэгийн томоохон үйлдвэрүүдэд 3 сар суралцах хугацаанд хэл усны хувьд маруухан тэднийг маань зохицуулах гэж Монгол элчин сайдын яам ихээхэн хүч чармайлт гаргасан билээ.

Мөн оны хавар техникийн туслалцааны эхний ээлж болох 5 сургалтын газрын тоног төхөөрөмжийг ачсан чингэлгүүд тус сургуулийн хашаанд бууж, тэдгээрийг суурилуулж, зүгшрүүлэхээр Энэтхэг улсын 6 мэргэжилтэн 3 сар шахам цаг нартай уралдан ажилласан сан. Ийн шаргуу ажилласны дүнд 2006 оны IX сард Энэтхэг улсын дэд ерөнхийлөгч /хожим ерөнхийлөгч болсон/ асан К.Р.Нараянаны Монголд хийсэн

төрийн айлчлалын үеэр Энэтхэг улсын техникийн туслалцааны жижиг үйлдвэрийн сургалтын төвийг албан ёсоор нээсэн юм.

Энэтхэг улсын техникийн туслалцааны хоёрдахь, гуравдахь үе шатны төслүүд 1999-2001 онуудад хэрэгжиж, компьютерийн программ хангамж, үнэт чулуу боловсруулах лаборатори, хэвлэлийн жижиг үйлдвэрийн сургалтын газруудыг ашиглалтад оруулсан.

Энэ хугацаанд Энэтхэг улсын 10 гаруй мэргэжилтэн тус сургуульд ажиллаж, мөн манай монгол багш нар Энэтхэгийн өндөр технологитой үйлдвэрт ажиллаж, англи хэлний сургалтад хамрагдаж байгаа нь Энэтхэгийн туслалцаатай байгуулагдсан жижиг үйлдвэрийн сургалтын газрыг үр ашигтай ажиллуулахад чухал үүрэг гүйцэтгэж байна.

БНЭУ-ын техникийн туслалцааг үр дүнтэй хэрэгжүүлэхэд Энэтхэг улсаас Монгол улсад сууж байсан элчин сайдууд мөн Монголоос Энэтхэг улсад ажиллаж байсан элчин сайдууд үнэтэй хувь нэмэр оруулсныг талархан тэмдэглэж байна. 1996 онд эхний сургалтын газруудыг ашиглалтад оруулах үед Энэтхэг улсаас Монгол улсад сууж байсан онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд агсан Бакула Рембүүчий багшийг талархан дурсаж байна. Тэр эрхэм хүн Энэтхэгийн туслалцааны анхны сургалтын газруудыг тус сургуульд хүлээлгэн өгөх актанд гарын үсэг зураад Энэтхэгийн ард түмний сэтгэл шингэсэн энэхүү туслалцааг Монголын залуу хойч үеийнхний тусын тулд сайн ашиглаарай хэмээн захисан билээ. Түүний захиасыг хүндэтгэн үзэх нь бидний үүрэг юм. Энэтхэг улсын техникийн буцалтгүй тусламжийг хэрэгжүүлэхэд анхнаас нь оролцож, өнөө хүртэл чин сэтгэлээсээ санаа тавьж байдаг Монгол улсаас Энэтхэг улсад сууж байсан элчин сайд, эдүгээ Төрийн ёслолын албаны даргаар ажиллаж буй О.Нямдаваа гуайг онцлон дурдахыг хүсэж байна. Энэ хүнийг элчин сайдаар ажиллаж байх үед туслалцааны гол хэсэг нь хэрэгжиж, Энэтхэгийн төр, нийгмийн нэр нөлөө бүхий олон зүтгэлтэн манай сургуульд зочилсон байдаг юм.

Ойрын жилүүдэд Үйлдвэрлэл-Урлалын сургуульд үзүүлэх Энэтхэг улсын техник, мэргэжилтний буцалтгүй туслалцааны цар хүрээ улам өргөжих юм. Энэ туслалцааны хүрээнд мэдээллийн технологийн сургалт, үйлчилгээний цоо шинэ орчин тус сургуульд бий болсноор орчин үеийн мэргэжилтэй ажилтан бэлтгэх чанарт мэдэгдэхүйц өөрчлөлт оруулах эхлэлийг тавих юм.



Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаяр, БНЭУ-ын Ерөнхийлөгч А.Каламтай хоёр орны харилцаа, хамтын ажиллагааны талаар санал солилцож байна.



Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаяр БНЭУ-ын Элчин сайд Ё.Вармаг Итгэмжлэх жуух бичгээ өргөн барьсаны дараа хүлээн авч уулзав.



Ардын хувьсгалын 85 жил, Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ойд БНЭУ-ыг төлөөлж оролцсон Дели хотын тэргүүн сайд хатагтай Шийла Диксит Монгол Улсын Ерөнхий сайд М. Энхболдод бараалхав.



Энэтхэг судлалын тов байгуулагдах үеэр